



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 111

Эрдэнэт

Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 7 дахь удаагийн сонгуулийн Ээлжит III хуралдааныг 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.


1. Аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

2. Аймгийн 2016 оны тодотгосон төсөв батлах тухай

3. Бусад

Хоёр. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ээлжит III хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

Гурав. Аймгийн ИТХ-ын Ээлжит III хуралдааны бэлтгэл хангаж хуралдуулахыг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга П.Пүрэвлхагвад даалгасугай.

ДАРГА  П.ПҮРЭВЛХАГВА

